Golomt Capital
Delivering diversity

Interactive Brokers

ТОЙМ

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024.09.30

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- S&P 500 индексийн зорилтот түвшний таамаглал шинэчлэгдлээ.
- Хувийн хэрэглээний үнийн индекс (PCE) 8-р сард 0.1%-иар өсөв.
- АНУ-д ипотекийн зээл олголт нэмэгдлээ.
- Хятадын хөрөнгийн зах зээл 16 жилийн дараа өндөр өсөлтийг үзүүллээ.
- Хятадын Ардын Банк (PBoC) 800 тэрбум юань буюу 114 тэрбум ам.долларoор хөрөнгийн захаа дэмжих шийдвэр гаргалаа.
- Хятад 7 хоногийн репо хүүг 0.2 хувиар бууруулав.

2024 он 9-р сарын 30

Dow Jones	42,313.00
S&P 500	5,738.17
Nasdaq	18,119.59
DAX	19,473.63
FTSE 100	8,320.76
S&P/ASX 200	8,276.60
HANG SENG	21,148.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.33%	0.45%	1.80%	12.27%	26.28%	23.27%
S&P 500	-0.13%	0.34%	1.59%	20.30%	33.82%	31.70%
Nasdaq	-0.39%	0.81%	2.29%	20.71%	37.07%	24.39%

2024 оны 9 сарын 30-ны 11:30

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	1.22%	3.33%	3.00%	16.25%	26.56%	28.48%
FTSE 100	0.43%	0.74%	-0.67%	7.60%	9.37%	18.41%

2024 оны 9 сарын 30-ны 11:30

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.78%	1.50%	2.27%	9.02%	17.41%	15.17%
Hang Seng	2.37%	15.69%	17.35%	23.83%	18.53%	-14.10%

2024 оны 9 сарын 30-ны 11:30

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ын голлох индексүүд бүх цаг үеийн дээд ханшаа шинэчлэн тогтоолоо.

АНУ-ын Dow Jones болон S&P 500 индексүүд түүхэн дээд түвшинд хүрч, хөрөнгө оруулагчид Хятад улсын эдийн засгийн шинэ идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүд болон хиймэл оюун ухааны салбарын өсөлтийг эергээр хүлээн авч байна. S&P 500 0.55%-иар, Dow Jones 0.5%-иар тус тус өссөн бөгөөд S&P 500 индекс 5785 ам.доллар дээр дээд ханшаа шинэчлэн тогтоолоо.

S&P 500 индексийн зорилтот түвшний таамаглал шинэчлэгдлээ.

Wall Street-ийн шинжээчид 2024 оны зорилтот түвшний таамаглалаа шинэчилж, BMO Capital Markets-ийн хөрөнгө оруулалтын ахлах стратегичид 2024 оны төгсгөлд S&P 500 индексийг 5,600-д хүрнэ гэж таамаглаж байсан бол 6,100 болгож өөрчлөөд байна.

2024 оны эцэст S&P 500 индексийн үнэ ашгийн харьцаа P/E 24.4 болж түүхэн дунджаас өндөр байхуйц байна. Энэ нь түүхэн хэвийн үзүүлэлттэй харьцуулахад өндөр мэт ч эдийн засагт soft landing буюу зөөлөн буух магадлал хамгийн өндөр гэж үзэж байна.

PCE хэрэглээний үнийн индекс

ХНС-ийн зорилтот инфляцын гол үзүүлэлт болох хувийн хэрэглээний үнийн индекс (PCE) 8-р сард 0.1%-иар өссөн нь хүлээлтээс бага үзүүлэлт болжээ. Жилийн дүнгээр индекс 2.2%-иар өссөн нь ХНС-ийн 2%-ийн урт хугацааны зорилтот түвшинд ойртсон бөгөөд 2021 оны 2-р сараас хойших хамгийн бага өсөлт юм.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл

Ипотекийн хүүгийн бууралт тогтворжиж эхэлсэн ч 8-р сард шинэ орон сууцны борлуулалт 4.7%-иар буурсан тухай Худалдааны яамнаас мэдээлэв. Гэсэн хэдий ч ипотекийн хүүгийн бууралт зээлээ дахин санхүүжүүлэх хүсэлтийг нэмэгдүүлж, Ипотекийн зээл олголтын индекс 2022 оны 4-р сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хувьцааны зах зээл сэргэлээ.

Өнгөрсөн долоо хоногт Хятадын хөрөнгийн зах зээл 16 жилийн дараа хамгийн сайн амжилтыг үзүүлж, CSI 300 индекс 15.7%-иар өсөв. Сүүлийн удаа индекс ийм өндөр өсөлтийг 2008 оны 11-р сарын 14-ний долоо хоногт үзүүлж байжээ.

Хятадын Ардын Банкны шийдвэр

Хятадын Ардын Банк (PBoC) өнгөрсөн долоо хоногт 800 тэрбум юань буюу 114 тэрбум ам.долларoор хөрөнгийн захаа дэмжихэд зарцуулах шийдвэр гаргав.

- Эхний 500 тэрбум юань нь своп хөтөлбөр энэ нь сангууд, даатгагчид болон брокерууд өөрт буй активаа бэлэн мөнгөөр сольж, түүгээрээ хувьцаа авах юм.
- Хоёр дахь 300 тэрбум юань нь хямд өртөгтэй зээлийг арилжааны банкнуудад олгож, эдгээр нь хувьцаа худалдан авах болон хувьцааны буцаан худалдан авалтыг санхүүжүүлэхэд чиглэгдэж байна.
- Санхүүгийн системийн богино хугацааны хөрвөх чадварыг удирдах чухал хэрэгсэл болох 7 хоногийн репо хүүг 0.2 хувиар бууруулахаар болжээ.
- Төв банкны ерөнхийлөгч Пан “Зээлийн жишиг хүүг (LPR) 0.2-0.25%-иар бууруулах магадлалтай” гэжээ. Энэ нь аж ахуйн нэгжүүд болон иргэдийн зээл авах зардлыг бууруулна.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн чиг хандлага

Өрхийн хөрөнгийн 70% нь үл хөдлөх хөрөнгөнд төвлөрсөн тул энэ зах зээл хүнд байдалтай байгаа үед иргэд шинэ зээл авах, зарцуулалтаа нэмэгдүүлэх хүсэлгүй хэвээр байна. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн илүүдэл нөөцийг 2018 оны түвшинд буюу хэвийн түвшинд хүргэхийн тулд 7.7 их наяд юань шаардлагатай байгаа нь одоогийнхоос 7 дахин их хөрөнгө шаардлагатай.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд